



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 594

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Соёл, Урлагийн Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 63,540,000.00 (жаран гурван сая таван зуун дөчин мянган) төгрөгийн балансын үнэ, 30,566,250.00 (гучин сая таван зуун жаран зургаан мянга хоёр зуун тавин) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Монгол Улсын Боловсролын Их Сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Соёл Урлагийн Их Сургуулийн захирал Э.Сонинтогос, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Мандах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
594... дугаар тогтоолын хавсралт

Соёл, Урлагийн Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Монгол Улсын Боловсролын Их Сургуульд
балансаас балансад шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
					Нэг бүрийн үнэ	Нийт үнэ		
1	Номын тавиур	ш	18	11/23/2013	60,000.00	1,080,000.00	495,000.00	585,000.00
2	Хөргөгч	ш	9	11/23/2013	350,000.00	3,150,000.00	2,887,500.00	262,500.00
3	Хувцасны өлгүүр	ш	9	11/23/2013	120,000.00	1,080,000.00	495,000.00	585,000.00
4	Хувцасны шүүгээ	ш	36	11/23/2013	480,000.00	17,280,000.00	7,920,000.00	9,360,000.00
5	Ширээ	ш	9	11/23/2013	230,000.00	2,070,000.00	948,750.00	1,121,250.00
6	Гал тогооны тавилга	ш	9	11/24/2013	640,000.00	5,760,000.00	2,640,000.00	3,120,000.00
7	Давхар ор	ш	36	11/24/2013	480,000.00	17,280,000.00	7,920,000.00	9,360,000.00
8	Матрасс	ш	72	11/24/2013	95,000.00	6,840,000.00	3,135,000.00	3,705,000.00
9	Сандал	ш	36	11/24/2013	30,000.00	1,080,000.00	495,000.00	585,000.00
10	Түшлэгтэй сандал	ш	72	11/24/2013	40,000.00	2,880,000.00	1,320,000.00	1,560,000.00
11	Ширээ /оюутны байр/	ш	18	11/24/2013	280,000.00	5,040,000.00	2,310,000.00	2,730,000.00
НИЙТ ДҮН					63,540,000.00		30,566,250.00	32,973,750.00
					(жаран гурван сая таван зуун дөчин мянган)		(гучин сая таван зуун жаран зургаан мянга хоёр зуун тавин)	